МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 28 өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн дүрмийн 16 дугаар зүйлийг тус тус үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Бага чуулганы дүрэм"-ийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ "7. Бага чуулганы бүрэлдэхүүнд тухайн салбарын академичид, Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагын захирал, төрийн өмчийн их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга, сонгогдсон гишүүдээс гадна төр, бизнес, төрийн бус байгууллагын 6 хүртэлх төлөөллийг тохиролцсоны дагуу оруулж болно. Байгууллагын төлөөллөөр ажиллах гишүүдийг ШУА-ийн Ерөнхийлөгчийн санал болгосноор ШУА-ийн Тэргүүлэгчид батална."

2/ "8. Бага чуулганы даргад Бага чуулганы гишүүн, доктор(Ph.D) ба түүнээс дээш зэрэгтэй эрдэмтнийг нэр дэвшүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар сонгоно. Бага чуулганы даргыг ШУА-ийн Ерөнхийлөгч батламжилна."

3/ "9. Бага чуулганы Орлогч дарга, Эрдэмтэн нарийн бичгийн даргыг Бага чуулганы шийдвэрийг үндэслэн ШУА-ийн Ерөнхийлөгч батламжилна. Орлогч дарга нь тухайн Бага чуулганы гишүүн байх ба Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын эрдмийн зэрэгтэй ажилтан байна."

2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Дэд ерөнхийлөгч (Б.Авид, Ц.Цэрэндорж), Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Ш.Ариунаа) нарт даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Х.ДЭМБЭРЭЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДОКТОР Ш.АРИУНАА

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 18 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, ШУА-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн "в" дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Бага чуулганы дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.АВИД

ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2020 оны
06. дугаар сарын 18-ны өдрийн хурлын
09. дугаар тогтоолын хавсралт

1119276877 9087044

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН БАГА ЧУУЛГАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрэм нь Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Бага чуулган /цаашид "Бага чуулган" гэнэ/-ы үйл ажиллагааг зохицуулахад мөрдөгдөнө.

2. Бага чуулган нь ШУА-ийн гишүүд, шинжлэх ухаан, технологийн салбарыг төлөөлөн сонгогдсон эрдэмтдээс бүрдэх ба түүний үйл ажиллагаа нь шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тулгамдсан асуудал, шинжлэх ухаан, технологийн ба шаардлагатай бусад төслийг хэлэлцэж дүгнэлт гаргах, судалгаа хөгжүүлэлтийн ажлын явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэнэ.

3. Бага чуулган нь үйл ажиллагаандаа Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай Монгол улсын хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай Монгол улсын хууль, Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн дүрэм болон энэхүү дүрэм, эрх зүйн бусад актыг мөрдлөг болгоно.

Хоёр. Бага чуулганы зохион байгуулалт

4. Академи нь шинжлэх ухааны салбараар зохион байгуулагдсан Бага чуулган, харьяа төрөлжсөн академитай байна. Шинжлэх ухааны Академийн эрхзүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу харьяа төрөлжсөн академи нь салбарын бага чуулганы үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5. Бага чуулган байгуулах шинжлэх ухааны салбар, гишүүдийн мэргэжлийн чиглэл, тооны хязгаарыг ШУА-ийн Тэргүүлэгчид тогтооно.

6. Бага чуулганыг зохион байгуулах сонгуулийг ШУА-ийн Тэргүүлэгч гишүүдийн төлөөлөл, тухайн шинжлэх ухааны салбарын академичдаас бүрдсэн Зөвлөл эрхлэн, санал хураалтыг нууцаар явуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ШУА-ийн Ерөнхийлөгч батална.

7. Бага чуулган нь тухайн салбарын академичид, сонгогдсон гишүүдээс бүрдэх ба төрийн төлөөлөл 3 хүртэл гишүүн байж болно. Төрийн төлөөллөөр ажиллах гишүүдийг ШУА-ийн Ерөнхийлөгчийн санал болгосноор ШУА-ийн Тэргүүлэгчид батална.

8. Бага чуулганы даргад Бага чуулганы гишүүн, академич хэргэмтэй эрдэмтнийг нэр дэвшүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар сонгоно. Бага чуулганы даргыг ШУА-ийн Ерөнхийлөгч батламжилна.

9. Бага чуулганы орлогч дарга, нарийн бичгийн даргыг Бага чуулганы шийдвэрийг үндэслэн ШУА-ийн Ерөнхийлөгч батламжилна. Орлогч дарга нь тухайн Бага чуулганы гишүүн байх ба нарийн бичгийн дарга нь ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын эрдмийн зэрэгтэй ажилтан байна.

10. Бага чуулганы гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Гишүүн журмын 24-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд нөхөн сонгууль явуулж болно. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа дараагийн ээлжит сонгууль явагдсанаар дуусвар болно.

11. Монгол Улсын Төрийн шагналд болон ШУА-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, Бага чуулганы дарга, гишүүнийг сонгох, гишүүнийг чөлөөлөх шийдвэр гаргах тухай асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

12. Бага чуулган нь албан бичгийн хэвлэмэл хуудастай байх бөгөөд ШУА-ийн тэмдгийг хэрэглэнэ.

Гурав. Бага чуулганы эрх, үүрэг

13. Бага чуулган нь дор дурдсан эрхтэй:

13.1. салбарын чиглэлээр гарсан судалгааны бүтээлийг шүүн хэлэлцэж, дүгнэлт гаргах;

13.2. бага чуулганы гишүүн болон шинжлэх ухааныг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан эрдэмтдээс Шинжлэх ухааны Академийн гишүүнд нэр дэвшүүлэх;

13.3. эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтныг шагнал, урамшуулалд дэвшүүлэх;

13.4. эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх талаар эрх бүхий байгууллагад санал гаргах;

13.5. бага чуулганы гишүүдийн ердийн олонх зөвшөөрсөн бол Академийн Их чуулганд санаачилгаараа асуудал оруулах.

14. Бага чуулган нь дор дурдсан үүрэгтэй.

14.1. засгийн газрын захиалгатай судалгаа хөгжүүлэлтийн ажил, хөтөлбөр, төслийг сонгон шалгаруулахад шинжээчийн үнэлгээ өгөх, магадлан шинжилгээ хийж холбогдох газарт оруулах;

14.2. суурь судалгааны төслийн тэйланг хэлэлцэн дүгнэлт гаргах,

14.3. салбарын шинжлэх ухааны зохион байгуулалт, хөгжлийн бодлогын асуудлыг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

14.4. салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар, үзэсгэлэн дангаараа болон хамтран зохион байгуулах;

14.5. улсын эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл, зөвлөмж боловсруулах;

14.6. эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

14.7.шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах.

Дөрөв. Бага чуулганы гишүүний эрх, үүрэг

15. Бага чуулганы гишүүн дор дурдсан эрх, үүрэгтэй.

15.1. тухайн салбарын чиглэлээр боловсруулсан судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөтөлбөр, шинжлэх ухаан, технологи, инновацийн болон суурь судалгааны төсөл, тэдгээрийн тайланд мэргэжлийн дагуу үнэлэлт өгөх, магадлан шинжилгээ хийх;

15.2. мэргэжлийнхээ дагуу шинжлэх ухаан-технологи, инновацийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдуулан санал, дүгнэлт гаргах;

15.3. академийн Их чуулганд зөвлөх эрхтэй оролцох;

15.4. ШУА-ийн гишүүний сонгуульд өрсөлдөхөөр Бага чуулганд нэрээ шууд дэвшүүлэх

15.5. зөвхөн нэг бага чуулган, эсвэл нэг төрөлжсөн академийн гишүүн байх

15.6. бага чуулганы гишүүний үүргийг биелүүлэхдээ эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлах.

Тав. Бага чуулганы ажиллах журам

16. Бага чуулганы үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Бага чуулган нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж хэлэлцсэн асуудлаар тогтоол, зөвлөмж, дүгнэлт гаргана. Хуралдааныг Шинжлэх ухааны Академийн ерөнхийлөгч, эсвэл бага чуулганы дарга зарлан хуралдуулна.

17. Бага чуулганы даргын эзгүйд хуралдааныг орлогч дарга удирдаж явуулна. Бага чуулганы нарийн бичгийн дарга хуралдааны бэлтгэлийг хангах, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцна. Хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтлөнө.

18. Бага чуулган нь удирдах байгууллага, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөс чиглэл болгосон болон шаардлагатай бусад асуудлыг хэлэлцэхдээ гишүүн бус эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулж, өргөтгөсөн, хамтарсан хуралдаан хийж болно. Өргөтгөсөн, хамтарсан хуралдаан хийх тухай шийдвэрийг Шинжлэх ухааны Академийн Ерөнхийлөгч гаргана.

19. Хэлэлцэх асуудлын талаарх зарыг Бага чуулганы хуралдаан эхлэхээс ажлын 3 өдрийн өмнө гишүүдэд хүргэнэ. Хуралдааны бэлтгэлийг хангуулах зорилгоор өмнө нь ажлын хэсэг ажиллуулж болно.

20. Бага чуулганы хуралдаан ердийн олонхийн ирцтэй байвал хүчинтэйд тооцно. Холбогдох дүрэм, журамд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын төрийн шагналд дэвшүүлэх, ШУА-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, бага чуулганы дарга, гишүүнийг сонгох,

гишүүнээс чөлөөлөх тухай асуудал хэлэлцэх хуралдааныг гишүүдийн 66-гаас дээш хувийн ирцтэйгээр зохион байгуулна.

21. Бага чуулган нь жилийн ажлын төлөвлөгөөтэй байна. Бага чуулганы үйл ажиллагааны жилийн тайланг Бага чуулганы дарга Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

Зургаа. Бага чуулганы гишүүнийг сонгох, чөлөөлөх

22. Бага чуулганы гишүүнд нэр дэвшүүлэх:

22.1. Бага чуулганы гишүүн нь бүтээл туурвилаараа тухайн салбарын шинжлэх ухаан, технологийн болон улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан, эрдэм судлалын ажлыг идэвхтэй хийж байгаа доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй хүн байна.

22.2. Бага чуулганы гишүүнд Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөл болон их сургуулиудын мэргэжлийн эрдмийн зөвлөлийн хурлаас зарласан чиглэл болон тоонд нийцүүлэн нэр дэвшүүлнэ.

22.3. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нууц санал хураалтаар ердийн олонхийн санал авсан эрдэмтнийг нэр дэвшсэн гэж үзнэ. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол Эрдмийн зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно.

22.4. Шинжлэх ухааны доктор нь Бага чуулганы гишүүнд нэрээ шууд дэвшүүлж болно.

22.5. Бага чуулганы гишүүнд нэр дэвшсэн эрдэмтний бүтээлийн жагсаалт, анкет, эрдмийн зөвлөлийн шийдвэр, холбогдох бусад материалыг сонгууль болохоос 14 хоногийн өмнө ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ.

22.6. ШУА-ийн Тэргүүлэгчид Бага чуулганы гишүүн сонгох мэргэжлийн чиглэл болон тоог сонгууль болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө нийтэд зарлан мэдээлнэ.

23. Бага чуулганы гишүүнийг сонгох

23.1. Бага чуулганд нэр дэвшигчийг энэ журмын 6-д заасан Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, биечлэн оролцсон гишүүдийн ердийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Бага чуулганы гишүүнээр сонгогдсонд тооцож, тооллогын комиссын хурлын тогтоол гаргана. Тооллогын комиссыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулна.

23.2. Бага чуулганы гишүүний нөхөн сонгуулийг энэ журмын 22 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшүүлж, Бага чуулганы хуралдаанаар хэлэлцэн нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

23.3. Бага чуулганы гишүүний сонгуулийн дүнгийн тухай шийдвэрийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталгаажуулна.

23.4. Сонгогдсон гишүүдэд энгэрийн тэмдэг, үнэмлэх олгоно. Үнэмлэх, тэмдэгийн загварыг Тэргүүлэгчид батална.

24. Бага чуулганы гишүүнээс чөлөөлөх

24.1. Дор дурьдсан тохиолдолд Бага чуулганы гишүүнээс чөлөөлнө.

24.1.1. гишүүн өөрөө хүсэлт гаргаснаар;

24.1.2. эрүүл мэндийн шалтгаан болон ажлын шаардлагаар;

24.1.3. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм зөрчсөн үндэслэлээр ;

24.1.4. энэхүү дүрмийн хоёр дахь хэсгийн 10-д заасан үндэслэлээр.

Долоо. Санхүүжилт

25. Шинжлэх ухаан, технологийн төсөлд магадлан шинжилгээ хийх, дууссан төслийн тайланд дүгнэлт гаргах ажилд оролцсон ажлын хэсгийн гишүүдэд уг ажилд зарцуулсан цагийн тооцоог үндэслэн тогтсон зохих журмын дагуу урамшуулал олгож болно.

---ooOoo---